



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг
улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн
гэрчилгээ олгох тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр, Ч.Тунгалаг, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, М.Батсуурь, Х.Батсүрэн, С.Батдэлгэр, Б.Батцэрэн, П.Золзаяа, Д.Мөнхтуяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Х.Батсүрэнгийн танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Өргөдөл гаргагч Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дарга Ц.Оюунгэрэлээс тус шүүхэд бичгээр ирүүлсэн өргөдөлдөө: Монгол Улсын нэр бүхий иргэд бид Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон хууль тогтоомжид заасан эвлэлдэн нэгдэх эрхийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр улс төрийн намыг үүсгэн байгуулах хурал дахин зохион байгуулж, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг албан ёсоор үүсгэн байгуулсан билээ. Тус намыг үүсгэн байгуулах хурлыг анх 2021 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулан улс төрийн нам бүртгүүлэхээр Улсын дээд шүүхэд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр миний бие өргөдөл гаргасан бөгөөд Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоолоор тус намын дүрмийг хуульд харшилсан гэж тогтоон бүртгэхээс татгалзсан юм. ИОНН үүсгэн байгуулах 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрээр Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолд үндэслэл болгосон зөрчлийг арилгасан болно. ИОНН нь Монгол Улсын тусгаар тогтнол, бие даасан урт хугацааны тогтвортой хөгжлийг иргэдийн идэвхтэй оролцоо, эрх, эрх чөлөөний тусламжтайгаар баталгаажуулахыг зорьж буй, баруун төв үзэл санааг баримталсан Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн чөлөөт, сайн дурын нэгдэл юм. Тус намыг үүсгэн байгуулах хурлыг орон нутгийн төлөөлөгчдийн оролцоотойгоор цахим, танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, намын дарга, намын удирдах төв байгууллага болох Төлөөлөгчдийн танхим, намын хяналтын байгууллага болох Маргаан таслах хорооны гишүүдийг сонголоо. Мөн ИОНН үүсгэн

байгуулсан талаар нийтэд зарлан мэдээлэв. Иймд Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж өгнө үү” гэжээ.

2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөр огноолж, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг тухайн намын дарга Ц.Оюунгэрэл гаргаж, өргөдөлд 7 хавтас¹, 2399 хуудас бүхий баримтыг хавсарган ирүүлснийг шүүх хүлээн авч, Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хавсралт “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-д заасан шаардлага хангасан эсэхэд нягтлан шалгах ажиллагаанууд явуулсан, энэ талаар үндэслэх хэсэгт тодорхой дурдах болно.

ҮНДЭСЛЭХ нь:

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг үүсгэн байгуулах Их Хурлыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр танхим-цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж, тус намын дарга Ц.Оюунгэрэлээс 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг Улсын дээд шүүхэд гаргасан нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т заасанд нийцжээ.

Өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан шаардлагатай мэдээллүүд бүрэн тусгагдсан байна.

1. ИОНН-ыг үүсгэн байгуулах Их Хуралд бэлтгэх ажлын хэсгийн 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаар Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын үүсгэн байгуулах Их Хурлыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр товлон зарлаж, www.zuv.mn, www.eduug.mn вэб сайтууд болон “Өдрийн сонин”-оор дамжуулан төлөөлөгч нарт мэдэгдсэн; нам үүсгэн байгуулах анхдугаар Их Хуралд Нийслэл, дүүрэг, орон нутгаас нийт таслах эрхтэй оролцох 95 төлөөлөгчийн тоог баталж, үүнээс 78 төлөөлөгч оролцсон нь Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3-т тус тус заасан зохицуулалтад нийцсэн.

2. ... үүсгэн байгуулах “Их Хурал”-ын хуралдааны дэг, журмыг тогтоож, хуралдааныг удирдах ... /бүрэлдэхүүнийг/ сонгосон, цахимаар өгсөн “санал” тоолох журмыг тогтоосон, Их Хурлаар намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэдэл, далбааны загвар, намын мөрийн хөтөлбөр, дүрмээ баталсан; намын удирдах төв байгууллага нь Төлөөлөгчдийн танхим, намын хяналтын байгууллагаар Маргаан

¹ 1-р хавтас (өргөдөл, намын нэр, итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээдийн мэдээлэл, нам үүсгэн байгуулах баримт бичиг, шийдвэр, хурлын тов, төлөөлөгчдийн бүртгэл, намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бэлгэдэл, далбаа, хаяг, санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий этгээдийн мэдээлэл, хөрөнгийн мэдээлэл, тэмдэгтийн хураамж төлсөн баримт);

2-р хавтас (намын гишүүдийн бүртгэл-Аймгууд);

3-р хавтас (намын гишүүдийн бүртгэл-Баянзүрх дүүрэг)

4-р хавтас (намын гишүүдийн бүртгэл-Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг)

5-р хавтас (намын гишүүдийн бүртгэл-Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг)

6-р хавтас (2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр гаргасан нам үүсгэн байгуулсныг бүртгүүлэх өргөдөл, түүнтэй холбогдох баримтууд)

7-р хавтас (мөн өмнөх үүсгэн байгуулах хуралтай холбоотой тогтоол, шийдвэр, холбогдох баримтууд)

таслах хороог тус тус сонгон байгуулж, бүрэлдэхүүнийг баталсан зэрэг нь Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 13 дугаар зүйлийн 13.3-т нийцжээ.

3. Намын мөрийн хөтөлбөр, намын дүрмийг шинжлэн судлахад, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрэм, мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд харшилсан агуулгагүй, намын үйл ажиллагааны зарчим, зорилго, үзэл баримтлал нь Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т заасныг зөрчөөгүй, түүнчлэн намын дүрэмд зохицуулбал зохих асуудлыг бүрэн, тодорхой тусгасан нь Улс төрийн намын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2-т заасан шаардлагыг хангасан гэж үзнэ.

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам гэсэн бүтэн нэрээр, “ИОНН” гэсэн товчилсон нэрээр улс төрийн намыг улсын бүртгэлд бүртгэхэд “нам оноосон нэртэй байх”, “намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж болон бусад намын нэртэй адил байхгүй байх” талаар Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага зөрчигдөөгүй, улс төрийн намын улсын бүртгэлд “Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам” нэртэй давхацсан нам байхгүй тул энэ нэрээр улс төрийн нам байгуулах нь “хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй” гэсэн Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасан шаардлагад нийцсэн байна.

Түүнчлэн, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хийлгэсэн нь өргөдөлд хавсаргагдсан байх тул Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3-т заасны дагуу намын нэрийг баталгаажуулсан гэж үзнэ.

Улс төрийн намын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3, 13 дугаар зүйлийн 13.3, 13.8-д заасны дагуу нам үүсгэн байгуулах 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Их Хурлаар Цэдэвдамба овогтой Оюунгэрэлийг ИОНН-ын даргаар сонгож, Намын Их хурлын чөлөө цагт ажиллах төлөөллийн байгууллага² болох намын Төлөөлөгчдийн танхимын гишүүд, хяналтын байгууллага³ болох Маргаан таслах комиссын гишүүдийг тус тус нууц санал хураалтаар сонгож шийдвэрлэсэн нь хуульд нийцсэн бөгөөд Их Хурлаар батлагдсан намын дүрмийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу явагджээ.

Мөн Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5, 9.3.8, 9.3.9-д тус тус заасан баримт бичгийн бүрдлийг дараах байдлаар хангуулан ирүүлжээ.

1. ИОНН-ын гүйцэтгэх байгууллага болох Үнэт зүйлийн зөвлөл⁴ нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3 дугаар хороо, 5-р хороолол, Нарны зам-53, Саруул төв, 107 тоот хаягт байрлаж, үйл ажиллагаа явуулахыг нотолж, Сүхбаатар дүүргийн 3-р хорооны Засаг даргын тодорхойлолт, “Монголглобал” ХХК-тай 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 13 мкв талбайтай оффисын өрөө тасалгааг түрээслэх түрээсийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ зэрэг баримтуудыг ирүүлсэн;

² Намын дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.6 дахь заалт.

³ Намын дүрмийн 19 дүгээр зүйл.

⁴ Намын дүрмийн 19 дүгээр зүйл.

2. Намын дүрэмд нь намын санхүүгийн асуудал эрхэлсэн эрх бүхий удирдах ажилтан, менежерийг Төлөөлөгчдийн танхимын хурлаас сонгож батлах зохицуулалттай байх бөгөөд ИОНН-амын Төлөөлөгчдийн танхимын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн хурлын 02 дугаар тогтоолоор ИОНН-ын Ерөнхий менежерээр Батсуурь овогтой Батмагнайг, ИОНН-ын бүртгэгчээр Мандах овогтой Хатантуулыг тус тус сонгож баталсан;

3. Намын дарга Ц.Оюунгэрэлийн нэр дээрх Хаан банкны дансан дахь хөрөнгийн мэдээ, үүсгэн байгуулах үйл ажиллагааны санхүүгийн болон зарцуулалтын тайлан, хандивын орлогын тайлан, зарлагын падаан зэрэг намын хөрөнгийн мэдээ зэрэг баримт бичгийн бүрдлийг ханган ирүүлсэн нь Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5, 9.3.8, 9.3.9-д тус тус заасанд нийцсэн.

Улсын дээд шүүхээс өргөдөлд хавсаргаж ирүүлсэн тухайн намын 1125 гишүүний мэдээлэл нь Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Монгол Улсын иргэн зөвхөн нэг намын харьяалалтай байна”, 9 дүгээр зүйлийн 9.3-т “Нам нь Улсын дээд шүүхэд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зүйлийн 16.1-д зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:” гээд 9.3.7-д “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг/;” гэж заасан шаардлага хангаж буй эсэх талаар тодруулахаар 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандахад тус газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 10/2583 дугаар албан бичгээр 151 иргэний мэдээлэл зөрүүтэй болох талаар хариу ирүүлсэн; түүнчлэн шүүхээс намын гишүүдийн бүртгэлээс тохиолдлын журмаар түүврийн арга ашиглан 140 иргэнээс утсаар холбогдон мэдээллийг нягтлан шалгахад, тухайн намд элссэн 105, элсээгүй 35 гэх нөхцөл байдал тогтоогдсон.

Эдгээрээс дүгнэвэл, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл зөрүүтэй 151, шүүхээс намын гишүүдийн бүртгэлээс тохиолдлын журмаар шалгахад илэрсэн 35, нийт 186 гишүүний бүртгэлд зөрчил илэрсэн болохыг тэмдэглэн, өргөдөлд хавсарган ирүүлсэн ИОНН-ын 1125 гишүүний бүртгэлээс уг зөрчилтэй гишүүдийг хасч тооцон тус намын гишүүдийн тоог 939 гэж үзэхэд, Улс төрийн намын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.3.7-д заасан “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл”-тэй байх гэж заасан доод хязгаарт хүрсэн байх тул мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй болно.

Иймд, Улс төрийн намын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т зааснаар намыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл тогтоогдоогүй тул Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох үндэслэлтэй гэж Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

ИОНН нь мөрийн хөтөлбөр, намын дүрмээ хуульд нийцүүлэн хэрэгжүүлж, Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль, бусад хууль тогтоомжийг зөрчихгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаагаа явуулах үүрэгтэй болохыг тэмдэглэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6-д заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосугай.

2.Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болсныг дурдсугай.

3.Монгол Улсын Үндсэн хууль, Улс төрийн намын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг дээдлэн сахиж ажиллахыг Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам /Ц.Оюунгэрэл/-д даалгасугай.

4.Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг улсын бүртгэлд бүртгүүлсэн болохыг нийтэд мэдээлсүгэй.

5.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянган) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Х.БАТСҮРЭН